



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/209

Булган сум

Мал эмнэлгийн ариун цэврийн аян,  
халдваргүйтгэлийн арга хэмжээ  
зохион байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 05 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, үхэж хорогдсон мал, амьтны сэг, зэмийг устгах, бэлчээр, хашаа хороо, өвөлжөө, хаваржаа болон худаг, уст цэгийн орчныг цэвэрлэж, ариутгал, халдваргүйтгэл хийх ариун цэврийн аяныг 2023 оны 04 дүгээр сарын 07-ноос 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Мал эмнэлгийн ариун цэврийн аян, халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулахад сумын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тус арга хэмжээнд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр оролцуулахыг сумын Засаг дарга нарт, ажлын явцад хяналт, тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА БАРИУН-ЭРДЭНЭ



Булган Ажил 2023 өдөр бүр Дос/2023/Захирамж

6323010205